



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 11753

Арвайхээр

### Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Залуучуудын усан спортын цогцолборын барилга угсралтын ажлын зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Н.Ганболд -аймгийн Засаг даргын дэргэдэх  
Орон нутгийн өмчийн газрын дарга

Нарийн бичгийн дарга: Ц.Оюун -аймгийн Засаг даргын дэргэдэх Орон  
нутгийн өмчийн газрын бараа, зөвлөх үйлчилгээ  
хариуцсан ахлах мэргэжилтэн

Гишүүд: Б.Мөнхбат -аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө  
оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн  
хэлтсийн мэргэжилтэн


В.Ганцэцэг (аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ахлах ажилтан)  
Ш.Авиurmэд (Бүтээлч хөгжлийн хөтөч ТББ-ын гишүүн) (зөвшилцсөнөөр)

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Н.Ганболд)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж архив-бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Ц.Оюун)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБОЛД



011101646

D:My Doc. Zahiramj. Zasag darga